

## МОНГОЛЫН АВТО ЗАМЧДЫН ХОЛБООНЫ ДҮРЭМ

2023 оны .....-р дугаар сарын .....-ний өдөр

Улаанбаатар хот

### НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. “МОНГОЛЫН АВТО ЗАМЧДЫН ХОЛБОО” төрийн бус байгууллага (цаашид МАЗХ гэж товчилно) нь “Монгол Улсын Үндсэн хууль”, “Авто замын тухай хууль”, “Төрийн бус байгууллагын тухай” хууль болон бусад хууль тогтоомж, олон улсын нийтлэг жишгийг баримталж, төрөөс хараат бус, үйл ажиллагаа нь олон нийтэд ил тод, энэхүү дүрмийг мөрдлөг болгон ажиллах, ашгийн төлөө бус, гишүүндээ үйлчилдэг, авто замын салбарын төрийн бус байгууллага мөн.
- 1.2. МАЗХ -ны оноосон нэр нь англиар “Mongolian Road Association” байна.
- 1.3. Албан ёсны хаяг: Монголын авто замчдын холбоо, Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хөрөө, Люкс центр—402 тоот.
- 1.4. МАЗХ нь Монгол Улсын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол Улсын Хууль Зүй, Дотоод Хэргийн Яаманд бүртгүүлсэнээр хуулийн этгээдийн эрх эдэлнэ.
- 1.5. МАЗХ нь өөрийн бэлэг тэмдэг (лого), тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх ба банк санхүүгийн байгууллагад харилцах данстай байна.
- 1.6. МАЗХ нь өөрийн нэрэмжит шагналтай байна.
- 1.7. МАЗХ нь 2008 оны 03 сарын 31-ны өдөр Монголын авто замчдын II Их хурлаас үүсгэн байгуулагдсан болно.
- 1.8. МАЗХ нь Монгол Улсын авто замын салбарын төрийн бус байгууллагуудын нэгдэл, “Нэгдсэн холбоо” бөгөөд орон нутагт болон олон улсад, гадаад оронд өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно. Мөн үйл ажиллагааг төрөлжүүлсэн зөвлөл, ажлын хэсэг, клубтэй байж болно.
- 1.9. МАЗХ нь зохих журмын дагуу жил, улирлын тайлан, тэнцэл, үйл ажиллагааныхаа тайланг холбогдох эрх бүхий байгууллагад хуулиар тогтоосон хугацаанд гаргаж өгнө.

### ХОЁР. Зорилго, үйл ажиллагааны чиглэл

- 2.1. Алсын хараа: Монголын авто замчдын холбоо нь Монгол Улсын төр, олон нийт, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, авто замын салбарын манлайлагч төрийн бус байгууллага байна.
- 2.2. Эрхэм зорилго, зорилт: Авто замын салбарын талаар төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагааг боловсруулахад идэвхи, санаачлагатай, манлайлан оролцож, төр, төрийн бус байгууллагын түншлэлийг хөгжүүлэх, салбарын хөгжлийг эрчимжүүлэхэд хувь нэмэр оруулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж гишүүдийнхээ ёс зүй, эв нэгдэл, ур чадавхийг хөгжүүлэх, мэдээллээр хангах, үйлчилгээ, туслалцаа үзүүлэх, эрх ашгийг хамгаалахад оршино.
- 2.3. МАЗХ нь “Эрхэм зорилго, зорилт”-оо биелүүлэхэд чиглэсэн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 2.3.1. Авто замын салбарыг хөгжүүлэх төрийн бодлогод санал өгөх, төр болон төрийн бус байгууллагатай түншлэлийн харилцаа холбоог хөгжүүлэх замаар гишүүдийнхээ эрх ашиг, сонирхолийг хамгаалах, тогтвортой хөгжлийг хангахад

- чиглэсэн үйл ажиллагаа явуулах;
- 2.3.2. Авто замын салбарын хууль эрх зүйн баримт бичиг, норматив, удирдлагын баримт бичиг, норм дүрэм, стандарт боловсруулахад оролцох, түүнийг хэрэгжүүлэх;
  - 2.3.3. Төрийн болон төрийн бус сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах бөгөөд гишүүдийнхээ инженер техникийн ажилтны болон мэргэжилтэй ажилтны ур чадварыг дээшлүүлэх, давтан сургалт эрхлэн явуулахаас гадна, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулах;
  - 2.3.4. Авто замын салбарын төр захиргаа, төрийн бус болон сургалт, эрдэм шинжилгээ, олон улс, олон нийтийн байгууллагууд, тэдгээрт ажиллаж байгаа ажиллагсадынхаа эрх ашгийг хамгаалах;
  - 2.3.5. Авто замыг хөгжүүлэх талаар баримталж байгаа төр засгийн бодлого үйл ажиллагааг дэмжиж Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан журам болон бусад байдлаар Засгийн газар болон бусад төрийн байгууллагуудтай хамтран ажиллах;
  - 2.3.6. Авто замын салбарын мэдээ, мэдээлэл цуглуулах, солилцох, түгээх, мэдээллийн сан байгуулан, архив үүсгэх, үйл ажиллагаандаа ашиглах, гишүүдээ мэдээллээр хангах, хууль эрх зүй, мэргэжлийн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах;
  - 2.3.7. Авто замын салбарт шинжлэх ухаан, техник технологийн ололтыг нэвтрүүлэх болон бусад чиглэлээр томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, энэхүү үйл ажиллагаандаа гишүүн байгууллага, гишүүдийг оролцуулж, нэгдсэн зохион байгуулалтын удирдлагаар хангах;
  - 2.3.8. Төрийн болон гүйцэтгэх засаглалын байгууллагаас гаргасан шийдвэрийн талаар авто замын салбарын байр суурийг илэрхийлэх;
  - 2.3.9. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр хурал, семинар, уулзалт, хэвлэлийн бага хурал, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах;
  - 2.3.10. Гишүүдээс гаргасан нийгмийн идэвхи санаачлага, урлаг соёл, спортыг хөгжүүлэхэд чиглэсэн олон нийтийн арга хэмжээнүүдийг зохион байгуулах;

### **ГУРАВ. Үйл ажиллагааны зарчим**

- 3.1. МАЗХ ны зохион байгуулалт, үйл ажиллагаа нь ардчилсан, нэгдмэл зарчимд тулгуурлана.
- 3.2. МАЗХ нь үйл ажиллагаандаа өмчийн хэлбэр, нутаг дэвсгэрийн байршил харгалзахгүйгээр гишүүн байгууллага болон гишүүндээ эрх тэгш үйлчлэх бөгөөд аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг баримтлана.
- 3.3. МАЗХ-ны дүрмийг хүлээн зөвшөөрсөн авто замын салбарын байгууллага, тэдгээрт албан ёсоор харъяалагдан ажиллаж байгаа албан тушаалтан, ажилтан, албан хаагч ажилчин нарыг холбооны гишүүн гэж зүй ёсоор тооцох бөгөөд ажлын байрны харъяалалгүй хувь хүн, гишүүнээр чөлөөтэй элсэх зарчим баримтлана.
- 3.4. МАЗХ нь “Монгол Улсын үндсэн хууль”, “Төрийн бус байгууллагын тухай” хууль бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- 3.5. МАЗХ нь гадаадын болон олон улсын ижил төрлийн байгууллагад гишүүнээр элсэж хамтын ажиллагаагаа өргөжүүлэхийг эрмэлзэнэ.
- 3.6. Төрийн ажлыг орлон гүйцэтгэхгүй, нам, улс төрийн үйл ажиллагаа явуулахгүй, гишүүдийг нас, хүйс, шашин шүтлэг, үзэл бодлоор ялгаварлахгүй.

## ДӨРӨВ. МАЗХ -ны бүтэц, зохион байгуулалт хяналтын тогтолцоо

- 4.1. МАЗХ нь өөрийн үйл ажиллагааг нээлттэй, нийгмийн бүх гишүүдэд хүртээмжтэй байлгахын тулд дараахь бүтэцтэй байна. Үүнд:
  - 4.1.1. Их хурал
  - 4.1.2. Зөвлөлдөх хороо
  - 4.1.3. Удирдах зөвлөл
  - 4.1.4. Ерөнхийлөгч
  - 4.1.5. Хяналтын зөвлөл
  - 4.1.6. Гүйцэтгэх захирал.
  - 4.1.7. Ажлын алба.
- 4.2. Үйлдвэрлэл болон нутаг дэвсгэрийн шинж байдлыг харгалзан МАЗХ-ны орон нутагт болон олон улсад байгуулах салбар, төлөөлөгчийн газар, үйл ажиллагааг төрөлжүүлсэн зөвлөл, ажлын хэсэг, клуб нь МАЗХ-ны удирдах зөвлөлөөс зөвшөөрөл авсан байна.
- 4.3. Салбар зөвлөлүүд нь Авто замчдын их хурал, зөвлөлдөх хороо, удирдах зөвлөл, хянан шалгах комиссын шийдвэр зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулж, МАЗХ-ны нэгдмэл удирдлага зөвлөлгөөг авч, тайлагнаж ажиллана.

### ТАВ. Их хурал

- 5.1. “Их хурал” нь Монгол авто замчдын холбооны эрх барих дээд байгууллага мөн бөгөөд авто замчдын болон авто замын салбарын төрийн бус байгууллагуудын эрх ашгийг хамгаалж буй байгууллага мөн тул “МОНГОЛЫН АВТО ЗАМЧДЫН ИХ ХУРАЛ” /цаашид “Их хурал” гэж товчлох/ гэж нэрлэнэ.
- 5.2. Их хурал нь ээлжит болон ээлжит бус хуралтай байх бөгөөд ээлжит хурлыг 3 жил тутамд хуралдуулна.
- 5.3. Дүрэмд заасны дагуу ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.
- 5.4. “МОНГОЛЫН АВТО ЗАМЧДЫН ИХ ХУРАЛ”-аар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.
  - 5.4.1. МАЗХ-ны “Зөвлөлдөх хороо”-ны ажлын тайлан болон салбарын хөгжлийн тулгамдсан асуудал;
  - 5.4.2. МАЗХ -ны “Хяналтын зөвлөл”-ийн тайланг хэлэлцэх;
  - 5.4.3. МАЗХ-ны дүрэм, үйл ажиллагааны хөтөлбөр батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;
  - 5.4.4. МАЗХ-ны “Зөвлөлдөх хороо”-ны болон “Хяналтын зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг сонгож, батлах;
  - 5.4.5. МАЗХ-ны “Зөвлөлдөх хороо”-ны 10 хүртлэх гишүүнийг олон нийтийн байгууллагаас квотоор оруулж болно;
  - 5.4.6. МАЗХ-ны “Ерөнхийлөгч”-ийг сонгох, чөлөөлөх;
  - 5.4.7. МАЗХ-г өөрчлөн зохион байгуулах, татан буулгах;

### ЗУРГАА. Зөвлөлдөх хороо

- 6.1. Их хурлаас Зөвлөлдөх хорооны гишүүдийг сонгох бөгөөд, Их хурлын чөлөөт цагт МАЗХ-ны үйл ажиллагааг 51 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөлдөх хороо удирдана.
- 6.2. МАЗХ-ны Зөвлөлдөх хороо жилд 1-ээс доошгүй удаа хуралдаж доор дурьдсан асуудлыг хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэнэ.

- 6.2.1. МАЗХ-ны ерөнхийлөгчийн тайланг хэлэлцэж, дүгнэлт гаргах;
  - 6.2.2. МАЗХ-ны тухайн оны хөрөнгө санхүүгийн төлөвлөгөөг батлах, түүний зарцуулалтанд хяналт тавих;
  - 6.2.3. Жилийн болон бүрэн эрхийн хугацааны ажлын төлөвлөгөөг хэлэлцэж батлах;
  - 6.2.4. Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
  - 6.2.5. Хяналтын зөвлөлийн мэдээллийг сонсож, зөвлөмж гаргах;
  - 6.2.6. МАЗХ нь “Сан” байгуулах тохиолдолд сангийн үйл ажиллагааны дүрэм батлах,
  - 6.2.7. МАЗХ-ны “Ажлын алба”, бүтэц, зохион байгуулалт, түүний төсвийг батлах;
  - 6.2.8. Бүрэн эрхийн хугацаанд орон гарсан, ажил үүргээ хангалттай биелүүлээгүй, ажлын хариуцлага алдсан, Зөвлөлдөх хорооны гишүүнийг сонгох, чөлөөлөх;
  - 6.2.9. МАЗХ ны ерөнхийлөгчийг чөлөөлөх хууль зүйн үндэслэл бий болсон гэж үзвэл Монголын авто замчдын ээлжит бус “их хурал”-ыг зөвлөлдөх хорооны бүх гишүүдийн дийлэнхи олонхийн (66%) шийдвэрээр хуралдуулж асуудлыг шийдвэрлэж болно;
  - 6.2.10. Цаг үеийн бусад асуудал
- 6.3 Гишүүдийн ирц 50 буюу түүнээс дээш хувьтай зөвлөлдөх хорооны хурал хүчин төгөлдөр байна.

#### ДОЛОО. Удирдах зөвлөл

- 7.1. МАЗХ-ны “Зөвлөлдөх хороо”-ны хурлаас удирдах зөвлөлийг 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр сонгоно.
- 7.2. Удирдах зөвлөлийн гишүүдийг Зөвлөлдөх хорооны хурлаар сонгож, чөлөөлнө.
- 7.3. Удирдах зөвлөл нь улиралд 1-ээс доошгүй удаа хуралдаж дараах асуудлыг хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэнэ.
  - 7.3.1. МАЗХ-ны Гүйцэтгэх захирлыг батламжлах бөгөөд “Ажлын алба”-ны орон тоо, үйл ажиллагааны төсөв, цалин, урамшуулалтын санг тогтоох.
  - 7.3.2. Улирлын ажлын төлөвлөгөө батлах.
  - 7.3.3. Цаг үеийн шаардлагатай бусад асуудал;
- 7.4 Удирдах зөвлөлийн гишүүдээс орон гарсан үед 3 сарын дотор саналаа боловсруулж Зөвлөлдөх хороогоор шийдвэрлүүлж, нөхөн сонгуулна.

#### НАЙМ. МАЗХ-ны ерөнхийлөгч

- 8.1. МАЗХ-ны ерөнхийлөгч нь 3 жилийн хугацаагаар их хурлаас сонгогдоно.
- 8.2. МАЗХ-ны ерөнхийлөгч нь дараах бүрэн эрхтэй байна.
  - 8.2.1. Ерөнхийлөгч нь “Удирдах зөвлөл”-ийн хамт Их хурал, Зөвлөлдөх хорооны шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.
  - 8.2.2. Зөвлөлдөх хорооны хурлыг дүрэмд заасан хугацаанд зарлан хуралдуулах, бэлтгэлийг хангаж, удирдах
  - 8.2.3. МАЗХ ны ерөнхийлөгч нь холбоог гадаад, дотоодод төлөөлөхөөс гадна төр, аж ахуйн болон төрийн бус байгууллагатай үр нөлөөтэй хамтран ажиллах.
  - 8.2.4. МАЗХ-ны ажлын албыг удирдан зохион байгуулах, хяналт тавих,
  - 8.2.5. Удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулан хуралдуулж, хуралдааныг даргалах
  - 8.2.6. МАЗХ-ны үйл ажиллагаатай холбогдсон гомдол бусад асуудлыг шалгах ажлыг зохион байгуулах

- 8.2.7. МАЗХ-ны өмч хөрөнгийг захиран зарцуулж, тайлагнах
  - 8.2.8. МАЗХ-ны Гишүүдийг шагнах, урамшуулах асуудлыг Ерөнхийлөгчид өргөн барьж шийвэрлүүлэх
  - 8.2.9. Эрх хэмжээнийхээ асуудлаар эрх зүйн акт гаргах
  - 8.2.10. Зөвлөлдөх хороо, Удирдах зөвлөлд орон гарсан тохиолдолд түүний оронд сонгогдох гишүүнийг дэвшүүлэх,
  - 8.2.11. Гүйцэтгэх захиралд нэр дэвшүүлэх, Удирдах зөвлөлөөс сонгосон Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах, түүнийг зөвлөмж, зааварчилгаагаар хангаж ажиллах,
  - 8.2.12. Тусгай санг Зөвлөлдөх хорооноос баталсан дүрмийн хүрээнд захиран зарцуулах эрхтэй.
- 8.3. МАЗХ-ны ерөнхийлөгчийн бүрэн эрх дуусгавар болсноор удирдах зөвлөлийн даргын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болно.
- 8.4. МАЗХ-ны ерөнхийлөгч нь гүйцэтгэх захирлын албыг хавсран гүйцэтгэж болно.

#### ЕС. Хяналтын зөвлөл

- 9.1. Хяналтын зөвлөл 3 хүний бүрэлдэхүүнтэй байна.
- 9.2. Хяналтын зөвлөл нь МАЗХ-ны үйл ажиллагаа, хөрөнгө, санхүүгийн зарцуулалтанд хяналт тавина.
- 9.3. МАЗХ-ны ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүн, Зөвлөлдөх хороо түүнчлэн ажлын албаны ажилтанг Хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгохгүй.
- 9.4. Хяналтын зөвлөл жилд 2 - оос доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд хуралдаж болно.
- 9.5. Хяналтын зөвлөл МАЗХ-ны үйл ажиллагаатайгаа холбоотой аливаа мэдээ, бичиг баримтыг саадгүй гаргуулан авах, холбогдох мэргэжлийн хүнийг хяналтын үйл ажиллагаанд татан оролцуулах эрхтэй.
- 9.6. Хяналтын зөвлөл дүгнэлт гаргаж илэрсэн дутагдлыг тухай бүр Зөвлөлдөх хороонд танилцуулж шаардлагатай арга хэмжээ авахуулна.

#### АРАВ. Гүйцэтгэх захирал

- 10.1. Гүйцэтгэх захирлыг МАЗХ -ны удирдах зөвлөлийн хурлаас батламжилна.
- 10.2. Гүйцэтгэх захирал нь Ажлын албыг удирдах бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
  - 10.2.1. Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд МАЗХ-ны өдөр тутмын дотоод үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
  - 10.2.2. Зөвлөлдөх хорооноос тогтоож өгсөн санхүүгийн төлөвлөгөөг удирдлага болгон Удирдах зөвлөлийн хурлаар баталсан ажлын албаны орон тоо, төсөв, бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажлын албыг удирдана.
  - 10.2.3. Удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулах, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангах;

#### АРВАН НЭГ. Ажлын алба

- 11.1. Гүйцэтгэх захирал нь үйл ажилгааны төлөвлөгөөгөө боловсруулах явцдаа Ажлын алба байгуулан ажиллах зайлшгүй шаардлагатай болохыг тодорхойлж, ажлын байрны тодорхойлолт боловсруулж, Удирдах зөвлөлийн хуралд танилцуулан шийдвэрлүүлэх үүрэгтэй.
- 11.2. Удирдах Зөвлөл Гүйцэтгэх захирлын саналыг үндэслэн тодорхой бүтэц,

бүрэлдэхүүнтэйгээр “Ажлын алба”-ыг байгуулна.

- 11.3. Ажлын албыг түр болон байнгын гэсэн хугацаатайгаар байгуулж болох бөгөөд Удирдах зөвлөлийн Ажлын албыг байгуулах тухай тогтоолд энэ тухай заавал тусгасан байна.
- 11.4. Ажлын албаны өдөр тутамын үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал удирдан зохион байгуулна.

#### **АРВАН ХОЁР. Гишүүнчлэл**

- 12.1. МАЗХ нь гишүүнчлэлтэй байна. МАЗХ-ны дүрмийг зөвшөөрсөн авто замын салбарын өмчийн бүх хэлбэрийн байгууллага тэдгээрийн ажиллагсад болон хувь хүн сайн дураараа МАЗХ-ны гишүүн байж болно.
- 12.2. МАЗХ-той ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг гадаадын болон гадаад улсын иргэн, байгууллага, гадаад оронд авто замын чиглэлээр ажиллаж, суралцаж байгаа Монгол Улсын иргэн гишүүнээр элсэж болно.
- 12.3. Монгол Улсад авто замын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын болон хамтарсан компани, аж ахуйн нэгж, Монгол Улсын харъяат иргэд гишүүнчлэлд хамрагдаж болно.
- 12.4. МАЗХ нь гишүүн, Хүндэт гишүүнээс бүрдэнэ.
- 12.5. Хүндэт гишүүнээр элсүүлэх асуудлыг МАЗХ-ны удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.
- 12.6. Гадаад орны хуулийн этгээд, хувь хүнийг МАЗХ-ны хүндэт гишүүнээр өргөмжилж болно.

#### **АРВАН ГУРАВ. МАЗХ-ны гишүүдийн бүрэн эрх**

- 13.1. МАЗХ-ны гишүүн нь дараах эрхийг эдэлнэ.
  - 13.1.1. МАЗХ – ны удирдах байгууллагад сонгох, сонгогдох;
  - 13.1.2. МАЗХ-ны удирдах байгууллагын үйл ажиллагаа, авто замын салбарын тулгамдсан асуудлыг хэлэлцэхэд идэвхтэй оролцож, үзэл бодлоо илэрхийлэх;
  - 13.1.3. Хууль тогтоомж, энэхүү дүрэмд заасны дагуу ашиг сонирхолоо илэрхийлэх, эрхээ хамгаалуулах, дэмжлэг туслалцаа хүсэх;
  - 13.1.4. Өөрийн хүсэлтээр МАЗХ-ны гишүүнчлэлээс татгалзах;
- 13.2. МАЗХ ны гишүүн дараах үүрэгтэй.
  - 13.2.1. Монгол Улсын хууль болон энэ дүрмийн шаардлагыг сахин биелүүлэх;
  - 13.2.2. Тогтоосон журмын дагуу жил бүр татвар төлөх ба хандив өгөх;
  - 13.2.3. МАЗХ-ны удирдах байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд удирдлагаас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу болон өөрийн хүсэлтээр идэвхтэй оролцох;
  - 13.2.4. Залгамж үеэ бэлтгэхэд биет туслалцаа үзүүлэх;
- 13.3. Энэхүү дүрэмд заасан гишүүний эрх, үүрэг нь зөвхөн гишүүнд хамаарна.

#### **АРВАН ДӨРӨВ. Гишүүнээр элсэх болон гарах журам**

- 14.1 МАЗХ-ны гишүүнээр элсэхийг хүссэн хувь хүн, хуулийн этгээд нь энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрч, дагаж мөрдөхөө илэрхийлсэн хүсэлтээ бичгээр гаргаж, Удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.
- 14.2. Ямар нэгэн шалтгаангүйгээр гишүүнээр элсүүлэхээс татгалзаж болохгүй.

- 14.3. Дараах тохиолдолд гишүүнээс **чөлөөлнө**.
- 14.3.1. Гишүүн нь МАЗХ-ны гишүүнээс гарах тухай хүсэлт гаргасан
  - 14.3.2. Гишүүн татвараа удаа дараа төлөөгүй
  - 14.3.3. МАЗХ-ны дүрэм, гишүүний үүргээ удаа дараа /2 ба түүнээс дээш/ зөрчсөн
  - 14.3.4. МАЗХ-ны дүрэм, **гишүүний үүргээ** ноцтой зөрчсөний **улмаас** МАЗХ-ны **үйл ажиллагаа, нэр хүндийг унагсан**, хууль ёсны ашиг сонирхолыг ямар нэг байдлаар хөндсөн, **бодиттой хохирол учруулсан**;
- 14.4. Гишүүн нь МАЗХ-ны гишүүнээс гарах хүсэлтээ удирдах зөвлөлд бичгээр гаргана;
- 14.5. Удирдах зөвлөл тухайн хүсэлтийг хүлээн авсанаас хойш **нэн даруй шийдвэрлэж, хариу мэдэгдэнэ**;
- 14.7. Ямар нэг шалтгаангүйгээр гишүүнээс гаргах хүсэлтийг шийдвэрлэхгүй байж болохгүй.
- 14.8. Удирдах зөвлөлийн санаачилгаар гишүүнээс **чөлөөлөх** тохилдолд тухайн **гишүүнд урьдчилан мэдэгдэж, хэлэлцэх хуралд биеэр оролцон тайлбар өгөх боломжоор хангах ба ямар зөрчлийн улмаас гишүүнээс чөлөөлж буйг** тодорхой дурьдсан үндэслэл бүхий тогтоол гаргана.
- 14.9. Гадаад орны хуулийн этгээд, иргэдийг тус МАЗХ-ны хүндэт гишүүнээр өргөмжилж батламжилж болно.

#### **АРВАН ТАВ. МАЗХ-ны санхүүгийн эх үүсвэр**

- 15.1. Санхүү нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
- 15.1.1. Гишүүн **байгууллага, гишүүний татвар, хандив, үйл ажиллагааны орлого, гадаад, дотоод дэмжигч байгууллага, хувь хүмүүсийн хандив, тусламж, гэрээслэлийн өв хөрөнгө, төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсөв, олон улсын байгууллагаас олгосон хөрөнгө зэргээс бүрдэнэ**;
  - 15.1.2. Төсөл хэрэгжүүлсэнээс олсон орлого;
  - 15.1.3. Зорилгоо хэрэгжүүлэхээр явуулсан аж ахуйн, **үйл ажиллагаа буюу үзэсгэлэн, ажил мэргэжлийн уралдаан, тэмцээн зохион байгуулах үйл ажиллагаанаас олсон орлого**
  - 15.1.4. Төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэхтэй холбоотой үйл ажиллагааны орлого;
- 15.2. Гишүүн байгууллага, гишүүн нь жил бүр гишүүнчлэлийн татвар төлөх бөгөөд татварын хувь хэмжээг Зөвлөлдөх хорооны хурлаас тогтоож мөрдүүлнэ;
- 15.3. Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор тусгай сан байгуулж болно;

#### **АРВАН ЗУРГАА. Холбооны санхүү**

- 16.1. Санхүүгийн үйл ажиллагааг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн **хуулийн дагуу явуулж, санхүүгийн жилийн тайлан, тэнцлийг гаргаж ажиллана**.
- 16.2. Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал нь МАЗХ-ын жилийн төсвийг гарган Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулна.
- 16.3. МАЗХ нь орлогоо зөвхөн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.
- 16.4. МАЗХ-ны үндсэн ба мөнгөн хөрөнгийг зөвхөн МАЗХ өөрөө эзэмшинэ. Дүрэмд заасан үйл ажиллагааг явуулахын тулд МАЗХ-ны нэр дээр бүртгүүлсэн байна.
- 16.5. МАЗХ нь санхүүжилтээ хэвийн байлгах зорилгоор **эрдэм шинжилгээ, судалгааны ажил, сургалт, сурталгаа явуулах**, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, хэвлэл гаргах ажил үйлчилгээ явуулж болно.

- 16.6. Засгийн газрын байрууллагуудтай тохиролцож төрийн зарим чиг үүргийг хуулийн хүрээнд гэрээний үндсэн дээр гүйцэтгэх, мэргэжлийн зөвлөлгөө дүгнэлт гаргах, магадлан шинжилгээ, төсөл боловсруулах нэгжийг дотоод нөөц бололцоондоо тулгуурлан ажиллуулж болно.
- 16.7. МАЗХ-ны хөрөнгийн (ашиглалт, эзэмшилт, мөнгөн хөрөнгийн орлого) зарцуулалтад их хурлаас сонгогдсон хяналтын зөвлөл жилд нэгээс доошгүй удаа шалгалт хийж дүнг Зөвлөлдөх хорооны хуралд оруулан хэлэлцүүлэх.
- 16.8. Ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал, удирдах зөвлөлийн гишүүн МАЗХ-ны хөрөнгөөр хувийн ашиг олох зорилгоор санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 16.9. Дүрэмд зааснаас өөр ажил үйлчилгээ явуулж ашиг олох, алдагдалтай ажил үйлчилгээ эрхлэх, бизнесийн тогтмол шинж чанартай үйл ажиллагаа эрхэлж болохгүй;
- 16.10. МАЗХ-ын эд хөрөнгийг хувь хүн аль нэг байгууллагад ашиг олох зорилгоор ашиглуулахыг хориглоно.
- 16.11. МАЗХ-ны хөрөнгийг шүүхийн шийдвэргүйгээр хураах, дайчлахыг хориглоно.

### **АРВАН ДОЛОО .Төрийн болон ТББ-тай харьцах журам**

- 17.1. Төрөөс хараат бус байж хуульд заасны дагуу эрхээ хамгаалуулна.
- 17.2. МАЗХ нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн дагуу салбарын өмнө тавигдаж байгаа зорилтыг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, энэ дүрмийн 2.3-д заагдсан үүргийг гүйцэтгэвэл төрөөс санхүүжилт болон бусад хэлбэрийн дэмжлэг авах эрхтэй.
- 17.3. Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудаас салбарын үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд хамтарч ажиллаж болно.
- 17.4. Шаардлагатай гэж үзвэл төрийн болон бусад төрийн бус байгууллагуудтай хамтарсан шийдвэр гаргаж болно.
- 17.5. Салбарын болон гишүүдийн эрх ашгийг илт хохироосон буруу шийдвэрийг төр засгийн байгууллага, албан тушаалтан гаргавал байр сууриа илэрхийлэх, шүүмжлэх, түүнийг өөрчлүүлэх, хүчингүй болгох, засуулах талаар шаардлага тавих, мэдэгдэл гаргах, улмаар эсэргүүцлийн арга хэмжээг хуульд нийцүүлэн зохион байгуулах эрхтэй.
- 17.6. ТББ-уудтай харилцан тохиролцсон асуудлаар хамтын шийдвэр гаргаж, үйл ажиллагааг зохион байгуулж болно.
- 17.7. МАЗХ нь Зөвлөлдөх хорооны шийдвэрийг үндэслэн Монгол Улсад ажиллаж байгаа бусад холбоо, нийгэмлэг, олон нийтийн байгууллагад гишүүнээр элсэж болно.
- 17.8. МАЗХ нь зохих журмын дагуу жилийнхээ тайлан тэнцлийг төрийн холбогдох байгууллагуудад хугацаанд нь гаргаж өгч байна.

### **АРВАН НАЙМ. Татан буулгах**

- 18.1. МАЗХ-г өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Их хурлаар шийдвэрлэнэ.
- 18.2. Адил төстэй чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагатай нэгдэх, нийлэх асуудлыг Их хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.
- 18.3. МАЗХ-г хуулийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буулгах тохиолдолд өр төлбөрийг төлж дууссаны дараа үлдэх хөрөнгийг салбарын ижил төстэй зорилго бүхий төрийн бус байгууллага, ийм байгууллага байхгүй тохиолдолд салбарын төрийн байгууллагад шилжүүлнэ.

### **АРВАН ЕС. Холбооны хүлээх хариуцлага**

- 19.1. МАЗХ нь “Төрийн бус байгууллагын тухай” хууль болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн



үйл ажиллагаа явуулсан тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээнэ.

19.2.МАЗХ нь өөрийн гишүүн болон МАЗХ-ны удирдах байгууллагын сонгуультны хууль бус үйл ажиллагаатай холбогдсон эд хөрөнгийн болон бусад хариуцлагыг хүлээхгүй.

## **МОНГОЛЫН АВТО ЗАМЧДЫН ХОЛБОО**

“Авто замчдын 4-р их хурлаар шинэчлэн батлав.”

---oo0oo---